



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/396

Номгон

“2017-2020 онуудад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалтад үзлэг шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай

Аймагт “2017-2020 онуудад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалтын чанарыг сайжруулах зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /д/, Барилга байгууламж ашиглалтын дүрмийн 2.1 , 3.4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймагт 2017-2020 онуудад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалтын чанарыг сайжруулахад үзлэг шалгалт хийх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох чиглэл бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Т.Норовринчин – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн барилга, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Ч.Сарайдамба – Мэргэжлийн хяналтын газрын Барилгын хяналтын улсын байцаагч

Н.Мөнхбаатар – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Л.Доржханд – Орон нутгийн өмчийн газрын Өмч хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга О.Эрдэнэ-Оюун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн


2. Аймагт 2017-2020 онуудад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалтын чанарт үзлэг шалгалт хийж, цаашид авах арга хэмжээний санал, ажлын хэсгийн тайланг 2021 оны 08 дугаар

621019999

сарын 20, 2022 оны 03 дугаар сарын 05-ны дотор хоёр удаа танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тус ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН